



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2020/12



УЛААНБААТАР ХОТ
2021 он

АГУУЛГА

Хуудасны
дугаар



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР

1



ТӨСӨВ

2



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

3



АЖ ҮЙЛДВЭР

7



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

9



ЭРҮҮЛ МЭНД

10



ГЭМТ ХЭРЭГ

13



МАЛ, АЖ АХУЙ

15

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2019 онд					2020 онд				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	313	Баянгол	7 842	Налайх	56	318	Баянгол	7 778	Налайх	56
			Чингэлтэй	1 793	Багануур	48		Чингэлтэй	1 722	Багануур	47
			Сүхбаатар	707	Багахангай	32		Сүхбаатар	707	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	77	Багахангай	821	Баянзүрх	73	58	Багахангай	790	Хан-Уул	57
			Багануур	179	Хан-Уул	63		Багануур	118	Баянзүрх	41
			Сүхбаатар	104	Сонгинохайрхан	51		Налайх	94	Сонгинохайрхан	25
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Налайх	15	Баянгол	7.2	12	Багахангай	24	Багануур	7
			Сүхбаатар	13.7	Хан-Уул	7		Сонгинохайрхан	12	Хан-Уул	6
			Сонгинохайрхан	12.4	Багахангай	-		Налайх	12	Сүхбаатар	5
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	141	Баянзүрх	199	Хан-Уул	126	118	Баянзүрх	110	Сүхбаатар	74
			Сонгинохайрхан	144	Налайх	111		Налайх	99	Хан-Уул	70
			Чингэлтэй	131	Багахангай	19		Сонгинохайрхан	95	Багахангай	26
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	65	Сүхбаатар	58	Налайх	12	65	Багахангай	76	Баянзүрх	29
			Чингэлтэй	56	Багануур	11		Хан-Уул	54	Баянгол	28
			Хан-Уул	48	Багахангай	6		Чингэлтэй	54	Сонгинохайрхан	24
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	208	Сүхбаатар	329	Налайх	132	150	Сүхбаатар	204	Сонгинохайрхан	107
			Чингэлтэй	245	Багануур	82		Чингэлтэй	174	Багахангай	93
			Баянзүрх	235	Багахангай	47		Баянзүрх	170	Багануур	74

Тайлбар:

* промиль

** продицмиль



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 2020 онд 32.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.4(5%) тэрбум төгрөгөөр илүү бүрджээ. Төсвийн нийт орлогын 18.5(56.4%) тэрбум төгрөгөөр татварын орлого, 0.9 (2.7%) тэрбум төгрөгөөр татварын бус орлого, 13.3(40.5%) тэрбум төгрөгөөр тусламжийн орлого бүрджээ. 2020 онд татварын нийт орлогын 14177.4(76.4%) сая төгрөгөөр орлогын албан татвар, 34.7(0.18%) сая төгрөгөөр өмчийн татвар, 1306(7.03%) сая төгрөгөөр газрын төлбөр, 16.8(0.09%) сая төгрөгөөр дотоод бараа үйлчилгээний татвар, 3030.7(16.3%) сая төгрөгөөр бусад татвар хураамжаас тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2. Дүүргийн төсвийн нийт орлого, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31 360.1	32 853.7	104.8
А. Урсгал орлого	17 889.7	19 484.3	108.9
1. Татварын орлого	16 877.4	18 565.6	110
1. Орлогын албан татвар	12 279.7	14 177.4	115.5
1.1. Хувь хүний орлогын албан татвар	3 174	3 072.7	96.8
1.2. Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	1900	3351.7	176.4
1.3. Иргэний хадгаламжийн хүүгийн орлого	6650	7051.6	106.04
1.4. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	555.7	701.5	126.2
2. Өмчийн татвар	36.6	34.7	94.8
2.1. Бууны албан татвар	36.6	34.7	94.8
3. Газрын төлбөр	1600	1305.9	81.6
3.1. Газрын 40 хувь	1600	1305.9	81.6
4. Дотоодын бараа үйлчилгээний татвар	20.1	16.8	83.6
4.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.1	16.8	83.6
5. Бусад татвар	2941	3030.8	103.05
5.1. Улсын тэмдэгтийн хураамж	865.1	761	88
5.2. Ус, рашаан ашигласны төлбөр	3.04	6.2	204
5.3. Хог хаягдлын хураамж	2 072.8	2 263.6	109.2
2. Татварын бус орлого	1 012.4	918.7	90.7
2.1. Хүү, торгуулийн орлого	617.5	490.5	79.4
2.2. Төсөвт газрын өөрийн орлого	142.1	140.4	98.8
2.3. Бусад нэр заагдаагүй орлого	252.8	287.8	113.8
3. Тусламжийн орлого	13 470.4	13 369.4	99.3
1. Нийслэлийн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	11 970	11 970	100
2. Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг	1 500.4	1 399.4	93.3


Тайлант хугацааны орлогын албан татвар төлөвлөснөөс 1897.7(15.5%) сая төгрөгөөр, бусад татвар 89.8(3.05%) сая төгрөгөөр өсч өмчийн татвар төлөвлөснөөс 1.9(5.2%) сая төгрөгөөр, газрын төлбөр 294.08(18.4) сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний татвар 3.3(16.4%) тус тус тасарсан байна. Орлогын албан татварыг бүрдүүдсэн иргэний хадгаламжийн хүүгийн орлого 401.6(6.04%) сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 145.8(26.2%) сая төгрөгөөр, хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 1451.7(76.4%) сая төгрөгөөр тус тус өссөн бол хувь хүний орлогын албан татвар 101.3 (3.2%) сая төгрөгөөр буурчээ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2020 оны 12-р сарын 12-ний байдлаарх өрхийн хэрэглээний үнийн ажиглалтаар Хангай захад 1 шүүдай хар мод 4000 төгрөг байгаа нь өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 1000 төгрөгөөр өссөн ханштай байна.

Зураг 1. Шатахууны үнэ, 12-р сард, төгрөгөөр




Дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг ШТС-уудад 12-р сард АИ-92 шатахуун дунджаар 1420 төгрөг, АИ-95 шатахуун 2000 төгрөг, дизель түлш 2090 төгрөг байна.

2020 оны 12-р сард дүүргийн хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалж буй махны дундаж үнийг өмнөх сартай харьцуулахад 1 кг үхрийн цул мах 11767 47(0.4%) төгрөгөөр , 1 кг хонины ястай мах


7807 131(1.7%) төгрөгөөр өссөн байна. Харин 1кг адууны мах 7937 төгрөг байгаа нь өмнөх сарын үнээс 1063(11.81) төгрөгөөр буурсан, 1кг ямааны ястай мах 8000 төгрөг байгаа нь өмнөх сартай харьцуулахад тогтмол ханштай байна.

Зураг 2. Хонины ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 12 сарын байдлаар





Өнгөрсөн оны 12 сард 1 кг хонины ястай мах 7807 төгрөг, үхрийн 1 кг ястай мах 9587 төгрөг байсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс хонины ястай махны үнэ 326(4.4%) төгрөгөөр өссөн бол үхрийн ястай мах 321(3.5%) төгрөгөөр өссөн байна.

Зураг 3. Үхрийн ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 12 сарын байдлаар




Зураг 4. Ямааны ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 12 сарын байдлаар



Тайлант оны 12-р сард дүүргийн хүнсний дэлгүүр, зах, худалдааны төвүүдэд жижиглэнгээр худалдаалж буй монгол төмс 1 кг нь дунджаар 894 төгрөг байгаа нь өмнөх сараас 180(25.2%) төгрөгөөр, монгол байцаа 1 кг дунджаар 1283 төгрөг байгаа нь өмнөх сараас 115 (22.5%) төгрөгөөр, монгол лууван 1 кг нь дунджаар 1330 байгаа нь өмнөх сараас 248(22.9%) төгрөгөөр, хятад сонгино 1 кг нь дунджаар 1746 төгрөг байгаа нь өмнөх сараас 46(7.4%) төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 6. Хүнсний ногооны дундаж үнэ, төгрөгөөр



Дүүргийн хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж буй Алтан тарианы савласан дээд гурилын дундаж үнэ 1 кг нь 1574төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 154(0.8%) төгрөгөөр өссөн, 1-р гурил 1кг нь дунджаар 1312 төгрөг байгаа нь 174(1.4%) төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны XI-XII сар, 2020 оны I-XII сар

Үзүүлэлт		хэмжих нэгж	2019 XII.28	2020 I.28	2020 II.28	2020 III.28	2020 IV.28	2020 V.28	2020 VI.28	2020 VII.28	2020 VIII.28	2020 IX.28	2020 X.28	2020 XI.28	2020 XII.28	<u>20.XI.28</u> <u>20.XII.28</u>
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	литр	1 900	1 900	1 900	1 900	1 900	1 900	1 900	1 900	1 900	2 245	2 250	2 250	2250	0.00
	дээд	литр	1 420	1 420	1 420	1 420	1 420	1 420	1 420	1 420	1 420	1 570	1 582	1 574	1574	0.00
	1-р зэрэг	ширхэг	1 138	1 138	1 138	1 138	1 138	1 138	1 138	1 138	1 138	1 302	1 310	1 312	1312	0.00
	2-р зэрэг	ширхэг	893	893	893	893	893	893	895	895	895	986	987	987	987	0.00
Сүү	Сүү ХК 1л	300 гр	2 718	2 730	2 730	2 740	2 756	2 756	2 756	2 756	2 756	2 830	2 852	2 852	2852	0.00
	Сүү ХК 0.5л	кг	1 152	1 192	1 192	1 192	1 192	1 214	1 214	1 214	1 214	1 276	1 322	1 322	1322	0.00
	Задгай	кг	1 767	1 933	1 933	1 933	1 933	1 933	1 467	1 467	1 433	1 550	1 548	1 548	1548	0.00
Тараг, Цөцгийтэй		200 гр	2 630	2 630	2 630	2 630	2 630	2 630	2 630	2 630	2 630	2 696	2 702	2 702	2702	0.00
Талх	Атар	1 литр	1 336	1 336	1 336	1 336	1 336	1 336	1 336	1 336	1 336	1 306	1 292	1 292	1292	0.00
	Зууван чех	90 гр	1 600	1 600	1 600	1 600	1 600	1 602	1 602	1 602	1 602	1 622	1 643	1 643	1643	0.00
	Хар талх	кг	1 120	1 120	1 120	1 120	1 120	1 120	1 120	1 120	1 120	1 214	1 248	1 248	1248	0.00
Будаа	цагаан заантай	кг	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4 050	4050	4050	0.00
	шар	кг	1 900	1 900	1 900	1 925	1 925	2 250	2 250	2 250	2 250	2 350	2 345	2 345	2345	0.00
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг	3 943	3 943	3 943	3 943	3 943	4 000	4 000	3 827	3 827	4 107	4 097	4 097	4097	0.00
Ургамлын тос, "Янта"		кг	3 878	3 878	3 878	3 898	3 898	3 898	3 938	3 958	3 958	3 868	3 857	3 857	3857	0.00
Ногоон цай, Гүрж		кг	1 568	1 568	1 568	1 568	1 568	1 568	1 568	1 568	1 568	1 576	1 604	1 604	1604	0.00
Элсэн чихэр /заантай/		кг	3 398	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 345	3 337	3 337	3337	0.00
Хонины мах	ястай	кг	7 633	8 787	8 787	8 983	8 850	9 688	9 600	9 100	8 733	7 617	7 601	7 676	7807	1.7
Үхрийн мах	ястай	кг	9 633	10 240	10 407	10 240	10 173	10 473	10 473	10 233	10 367	9 567	9 412	9 554	9587	0.3
	цул	кг	10 323	11 307	11 473	12 150	12 333	12 833	12 833	12 833	11 100	10 733	10 662	11 720	11767	0.4
Адууны мах, ястай		кг	8 500	10 000	10 000	9 800	9 800	10 000	10 000	9 000	9 000	9 000	9 000	7 937	7937	0.00
Ямааны мах, ястай		кг	6 200	8 000	8 000	8 500	8 500	8 500	8 500	8 000	8 000	8 000	8 000	8 000	8000	0.00
Төмс, монгол		ширхэг	950	958	958	958	998	888	1 738	1 818	818	706	657	714	894	25.2
Лууван, монгол		литр	1 400	1 710	1 710	1 710	1 663	1 633	1 800	1 738	1 498	1 135	1 064	1 082	1330	22.9
Байцаа, монгол		литр	1 350	2 090	2 090	2 090	1 990	1 888	2 500	1 998	1 758	1 208	1 093	1 168	1283	9.8
Хүрэн манжин, монгол		ширхэг	1 548	1 968	1 968	1 968	1 968	1 890	2 498	2 398	1 998	1 495	1 441	1 818	1818	0.00
Сонгино, хятад		ширхэг	1 440	1 563	1 563	1 563	1 550	1 580	1 500	1 480	1 440	1 726	1 713	1 792	1746	-2.6
Алим, фүжи		300 гр	5 498	4 986	5 646	5 646	5 546	5 546	5 546	5 278	5 158	5 206	5 088	5 088	5088	0.00
Өндөг, ОХУ		кг	372	374	374	374	366	366	366	362	362	366	363	371	371	0.0

Хүснэгт 4. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2016-2020 оны 12-р сараар

Үзүүлэлт			хэмжих нэгж	2016.XII	2017.XII	2018.XII	2019.XII	2020.XII	2020/2019	2020/2018	2020/2017	2020/2016
1	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1598	1636	1660	1900	1900	100.0	114.5	116.1	118.9
		дээд	кг	1310	1343	1386	1420	1420	100.0	102.5	105.7	108.4
		1-р зэрэг	кг	1080	1066	1070	1138	1138	100.0	106.4	106.8	105.4
		2-р зэрэг	кг	862	840	873	893	893	99.9	102.3	106.3	103.5
2	Сүү	Сүү ХК 1л	литр	2314	2303	2728	2718	2718	100.0	99.6	118.0	117.4
		Сүү ХК 0.5л	литр	956	957	1126	1152	1152	100.0	102.3	120.4	120.5
		Задгай	литр	1667	1775	1767	1767	1767	100.0	100.0	99.5	106.0
3	Тараг, Цөцгийтэй		литр	2236	2350	2532	2630	2630	100.0	103.9	111.9	117.6
4	Талх	Атар	ширхэг	1131	1183	1202	1336	1336	100.0	111.1	112.9	118.1
		Зууван чех	ширхэг	1600	1600	1600	1600	1600	100.0	100.0	100.0	100.0
		Хар талх	300 гр	893	928	998	1120	1120	100.0	112.2	120.7	125.4
5	Будаа	цагаан	кг	3154	3330	3700	4050	4050	100.0	109.5	121.6	128.4
		шар	кг	1853	1840	1750	1900	1900	100.0	108.6	103.3	102.5
6	Цөцгийн тос, "Сүү"		250 гр	3238	4750	4342	3943	3943	100.0	90.8	83.0	121.8
7	Ургамлын тос, "Янта"		1 литр	3476	3575	3908	3878	3878	100.0	99.2	108.5	111.6
8	Ногоон цай, Гүрж		90 гр	1540	1540	1568	1568	1568	100.0	100.0	101.8	101.8
9	Элсэн чихэр		кг	3360	3513	3570	3535	3630	102.7	101.7	103.3	108.0
10	Хонины мах	ястай	кг	3878	4378	6060	7633	7633	100.0	126.0	174.4	196.8
11	Үхрийн мах	ястай	кг	4880	5848	8463	9633	9633	100.0	113.8	164.7	197.4
		цул	кг	6660	6935	9120	10323	10323	100.0	113.2	148.9	155.0
12	Адууны мах, ястай		кг	4250	5667	7450	8500	8500	100.0	114.1	150.0	200.0
13	Ямааны мах, ястай		кг	3500	3775	6300	8000	8000	100.0	127.0	211.9	228.6
14	Төмс, монгол		кг	754	782	908	950	950	100.0	104.6	121.5	125.9
15	Лууван, монгол		кг	1317	1291	1248	1498	1498	100.0	120.0	116.0	113.8
16	Байцаа, монгол		кг	1065	1373	1240	1516	1516	100.0	122.3	110.4	142.3
17	Хүрэн манжин, монгол		кг	1925	1882	1336	1548	1548	100.0	115.9	82.3	80.4
18	Сонгино, хятад		кг	1321	1284	1244	1440	1440	100.0	115.8	112.1	109.0
19	Алим, фүжи		кг	4856	4813	4786	4986	4986	100.0	104.2	103.6	102.7
20	Өндөг, Дотоод		ширхэг	323	347	372	372	372	100.0	100.0	107.2	115.2



АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2020 онд 587.03 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 623.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. Дүүргийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 453.3(77.2%) тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 113.6(22.7%) тэрбум төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна. Нийт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 85.1(18.7%) тэрбум төгрөгийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 161.7(35.6%) тэрбум төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 95.3(21.0%) тэрбум төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл, 39.8(8.7%) тэрбум төгрөгийг ундаа үйлдвэрлэл, 71.1(15.6%) тэрбум төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна.


Хүснэгт 5. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр

Салбар	Үйлдвэрлэл	Борлуулалт
Бүгд	587 033.8	623 231.6
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ	453 358.5	506 113.8
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	85 153.4	86 540.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	161 774.3	170 582.6
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	95 394.6	113 400.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	71 185.2	71 486.5
Архи ус ундаа үйлдвэрлэл	39 850.8	64 103.8
ХҮНСНИЙ БУС БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ	133 675.3	117 117.8
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	26 495.1	22 939.7
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2 569.5	3 173.8
Бусад үйлдвэрлэл	104 610.7	91 004.3

Тайлант онд нийт үйлдвэрлэсэн хүнсний бус бүтээгдэхүүний 26.4(19.7%) тэрбум төгрөгийг химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2.5(1.8%) тэрбум төгрөгийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн үйлдвэрлэл, 104.6(78.2%) тэрбум төгрөгийн бусад хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

Дүүргийн аж үйлдвэрийн газруудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн өнгөрсөн оноос 28.3(5.0%) тэрбум төгрөгөөр, борлуулалт өнгөрсөн оноос 41.5(7.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Тайлант онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын 506.1(81.2%) тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, 117.1(18.8%) тэрбум төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт тус тус эзэлж байна.

Зураг 7. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, тэрбум төгрөгөөр



Тайлант хугацаанд нийт хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын 86.5(17.0%) тэрбум төгрөгийг мах, махан бүтээгдэхүүний борлуулалт, 170.5(33.6%) тэрбум төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалт, 113.4(22.4%) тэрбум төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээлийн борлуулалт, 64.1(12.6%) тэрбум төгрөгийг ундааны борлуулалт, 71.4(14.1%) тэрбум төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна. Хүнсний бус бүтээгдэхүүний нийт борлуулалтын 22.9(19.5%) тэрбум төгрөгийг химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 3.1(2.6%) тэрбум төгрөгийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн үйлдвэрлэл, 91.1(77.9%) тэрбум төгрөгийн бусад хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна.

Хүснэгт 6. Хүнсний гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Биет хэмжээ		Үнийн дүнгээр (сая.төг)	
		1-12 сар	12 сар	1-12 сар	12 сар
Үхрийн мах	тн	559.2	46.2	3861.6	376.1
Гахайн мах	тн	542.7	44.0	4643.8	387.3
Хонины мах	тн	1536.7	165.8	8606.8	1044.6
Ямааны мах	тн	658.9	152.0	3887.1	867.2
Адууны мах	тн	3239.8	825.0	16713.5	3986.9
Хиамны зүйл	тн	3278.2	465.2	40093.9	6437.4
Боловсруулсан шингэн сүү	мян.л	22108.6	2018.0	49687.3	5156.3
Тараг	мян.л	8888.7	884.3	24033.8	2358.6
Аарцны ундаа	мян.л	6453.7	868.8	13032.8	2275.6
Цөцгийн тос	тн	182.0	16.8	3315.4	324.8
Аарц	тн	515.9	90.1	11667.7	2016.2
Гурил Дээд	тн	26724.1	3026.3	27155.0	3122.8
Гурил I зэрэг	тн	45910.0	6767.7	38741.5	5924.6
Гурил II зэрэг	тн	7213.9	255.1	4298.8	164.3
Нарийн боов	тн	4884.2	546.4	23135.1	3108.1
Талх	тн	15943.0	1734.2	41599.1	4525.1
Гоймон	тн	4548.9	105.2	7182.1	246.6
Спирт	мян.л	1274.5	20.0	5574.0	87.4
Архи	мян.л	3042.1	113.9	24316.4	889.8
Амны хаалт (маск)	мян.ш	4.945	0	7417.5	0
Нүүрсэн шахмал түлш	тн	553370.0	116800.0	83005.5	17520.0
Тарилгын эм	мян.ампул	1105.3	62.3	1168.1	58.6
Шахмал эм	мян.боодол	10381.4	1562.4	7368.3	762.0
Шингэн эм	тн	518.0	4.2	1625.8	169.8
Эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай бусад төрлийн эм, ариутгалын бэлдмэл	мян.л	467.8	28.0	11306.4	856.4

Сонгинохайрхан дүүргийн махны үйлдвэрүүд тайлант онд 559.2 тонн үхрийн мах, 1536.7 тонн хонины мах, 658.9 тонн ямааны мах, 3239.8 тонн адууны мах боловсруулсан бол 12 дугаар сард 46.2 тонн үхрийн мах, 165.8 тонн хонины мах, 152 тонн ямааны мах, 825.0 тонн адууны мах үйлдвэрлэсэн байна. Сүүний үйлдвэрүүд 12 сард 2018 мянган литр шингэн сүү, 884.3 мянган литр тараг, 868.8 мянган литр аарцны ундаа үйлдвэрлэсэн байна. Гурилын үйлдвэрүүд тайлант онд нэгдүгээр зэргийн гурил 45910 тонныг үйлдвэрлэснээс 6767.7(14.7%) нь 12 сард үйлдвэрлэсэн байна. Дүүргийн хүнсний үйлдвэрүүд 12 сард 1734.2 тонн талх, 546.4 тонн нарийн боов, 105.2 тонн гоймон үйлдвэрлэжээ.

Сайжруулсан түлшний үйлдвэрт 12 дугаар сард 116800 тонн нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэсэн байна. Эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үйлдвэрүүд 62.3 мянган ширхэг тарилгын эм, 4.2 тонн шингэн эм, 28.0 мянган литр эмнэлэгийн ариутгалын бэлдмэл үйлдвэрлэсэн байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

2020 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 296 байгаагаас 161(54.3%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 8(2.7%) нь магистр, доктор, 95(32.0%) нь дипломын болон бакалаврын дээд, 20(6.7%) нь тусгай мэргэжлийн дунд, 15(5.0%) нь техникийн болон мэргэжлийн, 149(50.3%) нь бүрэн дунд, 6(2.0%) нь суурь, 1(0.3%) нь бага түвшиний боловсролтой, 2(0.6%) нь боловсролгүй, 6(2.0%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Хүснэгт 7. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо, боловсролын түвшин, насны бүлгээр

Ажил хайгч иргэн /сарын эцэст/	Боловсролын түвшин							
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор
296	2	1	6	149	15	20	95	8
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Насны бүлэг						
		15-24	25-34	35-44	45-54	55-59	60+	
	6	22	123	89	47	11	4	

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 22(7.4%) нь 15-24 насны, 123(41.5%) нь 25-34 насны, 89(30.0%) нь 35-44 насны, 47(15.8%) нь 45-54 насны, 11(3.7%) нь 55-59 насны, 4(1.3%) нь 60, түүнээс дээш насны иргэд байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 5 хүн ажилд зуучлагдан орсноос 1(20.0%) нь 15-24 насныхан, 2(40.0%) нь 25-34 насныхан, 1(20.0%) нь 35-44 насныхан, 1(20.0%) нь 55-59 насны иргэд байна. Ажилд зуучлагдан орсон иргэдийн 1(20.0%) нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, 3(60.0%) нь бүрэн дунд боловсролтой, 1(20.0%) нь боловсролгүй байна.

Хүснэгт 8. Ажил хайгч иргэдийн тоо, 12-р сард

Үзүүлэлтүүд		Бүгд
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/		315
Эмэгтэй		167
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн		137
Эмэгтэй		79
Ажил хайж байгаа /шалтгаанаар/	Шилжин суурьшсан	23
	Сургууль төгсөөд ажилгүй байгаа	17
	Сургуулиа орхисон /гарсан, чөлөө авсан/	1
	Цэргээс халагдаад ажилгүй байгаа	3
Ажлаас чөлөөлөгдсөн / халагдсан/	Мэргэжлийн ур чадварын хувьд тэнцэхгүй болсон	1
	Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон	7
	Тэтгэвэрт гарсан	3
	Хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан	4
	Орон тооны цомхотголд орсон	48
	Байгууллага татан буугдсан	9
	Бусад	19
Тайлант хугацаанд хасагдсан иргэн		156
Ажилд зуучлагдан орсон иргэн		5
Ажил хайгч иргэн /сарын эцэст/		296
Эмэгтэй		161



ЭРҮҮЛ МЭНД


2020 онд 7119 эхээс 7175 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн онд 7245 эхээс 7313 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 87 гарсан нь өмнөх оноос 4.0(4.4%)-аар буурч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 12 гарсан байгаа нь өмнөх оноос 3.0(20%)-аар буурсан байна. Харин тайлант хугацаанд эхийн эндэгдэл 4 гарсан нь өмнөх оноос 2-оор өссөн байна. Тайлант оны 12 сард 0-1 настай хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 12.13 промилл ногдож байгаа нь өнгөрсөн оноос 0.27 промиллоор буурсан байна.

Хүснэгт 9. Төрөлт, нас баралт

Үзүүлэлтүүд	2019.12		2020.12	
	Бодит тоо	1000 хүн амд	Бодит тоо	1000 хүн амд
Төрсөн эх	7245		7119	
Амьд төрсөн нярай	7313		7175	
Нийт нас баралт	1522		1581	
0-1 насны хүүхдийн эндэгдэл	91	12.4	87	12.13
1-5 насны хүүхдийн эндэгдэл	15	2.1	12	1.67
Эхийн эндэгдэл	2	27.3	4	55.75

Тайлант хугацаанд халдварт өвчнөөр өвчилсөн 9080 хүн бүртгэгдсэн нь өмнөх оноос 1556(33.6%) тохиолдлоор буурсан бөгөөд 10000 хүнд ногдох халдварт өвчин 94.6 промилл байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 37.4 промиллоор буурсан байна. Халдварт өвчний гаралтыг өмнөх онтой харьцуулбал цусан суулга 705(55.6%) тохиолдлоор, улаан эсэргэнэ 107(73.3%) тохиолдлоор, гепатит 6(14.3%) тохиолдлоор, салхинцэцэг 803(75.7%) тохиолдлоор, сальмонеллэз 13(22.1%) тохиолдлоор, ёлом 9(33.3%) тохиолдлоор, ГХА өвчин 39(20.6%) тохиолдлоор, хоолны хордлого 52(85.2%) тохиолдлоор, Эритема В08.3 2(100.0%), Тэмбүү 75(10.9%), Трихомониаз 69(20.9%), Төрөлхийн тэмбүү 9(64.3%) тохиолдлоор тус тус буурсан байна. Харин шинээр илэрсэн сүрьеэ өвчин 14(2.8%), Заг хүйтэн 130(41.4%), А84 Хачигаар дамжих вирүст энцефалит 1, А69 Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар 1, Covid-19 71-н тохиолдол, Б34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй 133, Мөөгөнцөр 2 тохиолдлоор тус тус өссөн байна. Харин шинээр илэрсэн сүрьеэ өвчин 14(2.8%), Заг хүйтэн 130(41.4%), А84 Хачигаар дамжих вирүст энцефалит 1, А69 Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар 1, Covid-19 71-н тохиолдол, Б34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй 133, Мөөгөнцөр 2 тохиолдлоор тус тус өссөн байна.

Зураг 9. Халдварт өвчний гаралт, төрлөөр




Хүснэгт 10. Халдварт өвчний гаралт, төрлөөр

Үзүүлэлтүүд	2019.12		2020.12		УБ хот	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Бүгд халдварт өвчин	4636	131.9	3080	94.6	13224	94.5
Үүнээс цочмог халдварт өвчин	2900	82.4	1209	37.1	5758	41.1
Цусан суулга	1269	37.3	564	17.3	1886	12.9
Улаан эсэргэнэ	146	4.2	39	1.2	170	1.1
Менингит	0	0.03	1	0.03	3	0.02
Нярайн халдвар	0	0.00	2	0.06	2	0.01
Гепатит	42	1.09	36	1.11	140	0.96
Салхинцэцэг	1061	28.93	258	7.92	1512	10.38
Гахайн хавдар	9	0.25	8	0.25	41	0.28
Сальмонеллэз	59	1.71	46	1.41	155	1.06
Бруцеллэз	1	0.03	0	0.0	10	0.07
Ёлом	27	0.84	18	0.55	73	0.5
ГХА өвчин	189	5.8	150	4.6	955	6.5
Хачигт рикеттикоз	2	0.06	4	0.12	15	0.1
Хоолны хордлого	61	0.0	9	0.2	114	0.7
A69 Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар	1	0.0	2	0.06	4	0.03
Covid-19	0	0.00	71	2.18	668	4.59
Эритема B08.3	2	0.03	0	0.0	7	0.05
B34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй	0		133	4.08	715	4.91
A84 Хачигаар дамжих вируст энцефалит	0	0.06	1	0.03	1	0.01
Тэмбүү	693	19.38	618	18.98	2587	17.76
Заг хүйтэн	314	8.96	444	13.63	1103	7.57
Шинэ илэрсэн сүрьеэ	496	14.27	510	15.66	1936	13.29
Трихомониаз	231	5.61	162	4.97	941	6.46
Төрөлхийн тэмбүү	14	0.37	5	0.15	13	0.09

Тайлант онд дүүргийн эмнэлгийн байгууллагууд 1473077 үзлэг хийсний 555407(37.7%) нь урьдчилан сэргийлэх, 347579(23.5%) нь гэрийн үзлэг байна. Дүүргийн эмнэлгийн орны тоо 388, ор хоногийн ашиглалт 105428 байна.

Тайлант хугацаанд 7821 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 347(4.4%) нь цус багадалттай, 63(0.8%) нь трихомониаз, 209(2.6%) нь тэмбүүгийн өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 7012(89.6%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна.


Зураг 10. Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүд , 2020.12 сарын байдлаар



2020 онд артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 134359 хүн хамрагдсанаас 74827(55.6%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 2717(31.0%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 110047 хүн хамрагдсанаас 61127(55.5%) нь эмэгтэйчүүд байна.

Тайлан онд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан нийт хүний 134359(49.8%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 110047(40.8%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 24177(9.4%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

Зураг 11. Эрт илрүүлгийн үзлэгийн тоо, өвчний төрлөөр



Тайлант хугацаанд амбулаторт 46692 халдварт бус өвчлөл бүртгэгдсэний 27188(58.2%) нь шинээр бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 0-5 насны 152443 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгасан байна. Амбулатороор үзүүлсэн 0-5 насны хүүхдүүдийн 720(0.4%) нь туранхай, 465(0.3%) нь тураалтай, 599(0.3%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Тайлант хугацаанд амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 36542 хүүхэд А амин дэм, 60116 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

Хүснэгт 11. Амбулаторийн өвчлөлийн үзүүлэлтүүд


Үзүүлэлт		Тоо
Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл-Бүгд		46692
	Шинэ	27188
	Хуучин	19504
Хорт хавдрын өвчлөл		154
Осол гэмтлийн өвчлөл		59
Томуу, томуу төст өвчин (J09-J11)		273
0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчин (K52.0-K52.9)		121
0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин (J00-J06, J20-J22)		698
0-5 хүртэлх насны жинлэсэн хүүхдийн тоо		152443
	Туранхай /жин, өндрийн үзүүлэлт/	720
	Тураалтай /жин, насны үзүүлэлт/	465
	Өсөлтийн хоцрогдолтой /өндөр, насны үзүүлэлт/	599
	А амин дэм уусан	36542
	Д амин дэм уусан	60116
	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн	0



ГЭМТ ХЭРЭГ

2020 онд Сонгинохайрхан дүүрэгт нийт 2337 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1133(32.7%) хэргээр буурсан байна. Тайлант хугацаанд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 1144(51.1%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 614(27.4%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 579(25.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгджээ.

Зураг 12. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хувиар



Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт хэргийн 1787(79.8%) нь хөнгөн гэмт хэрэг, 550(20.2%) нь хүнд гэмт хэрэг байна. Тайлант онд бүртгэгдсэн нийт хэргийн 794(35.4%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 47(2.1%) нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 1257(56.1%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 59(2.6%) нь хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 104(4.6%) нь хөдөлгөөний аюулгүй

байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 13(0.6%) хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг байна. Тайлант хугацаанд үйлдэгдсэн хэргийн 321(14.3%) нь согтуугаар, 110(4.9%) нь хүүхэд оролцсон, 289(12.9%) нь эмэгтэй хүн оролцсон, 116(4.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг байна. Тайлант хугацаанд нийт үйлдэгдсэн хэргийн 1012(45.2%) нь гэр орон сууцанд, 421(18.8%) нь гудамж талбайд, 160(7.1%) нь олон нийтийн газарт, 37(1.6%) нь нийтийн тээвэрт, 12(0.5%) нь төрийн байгууллагад, 12(0.5%) нь төрийн бус байгууллагад, 174(7.7%) нь аж ахуйн нэгжид, 104(4.6%) нь авто зам дээр тус тус гарсан байна.

Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн хэргийн 362(16.1%) нь Даваа гарагт, 344(15.3%) нь Мягмар гарагт, 350(15.6%) нь Лхагва гарагт, 343(15.3%) нь Пүрэв гарагт, 337(15.0%) нь Баасан гарагт, 304(13.5%) нь Бямба гарагт, 297(13.2%) нь Ням гарагт тус тус гарчээ.

Гэмт хэргийн гаралтыг хороогоор харвал 6-р хороонд 106 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 24(22.6%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг байна. Харин хамгийн бага гэмт хэрэг гарсан 39-р хороонд бүртгэгдсэн 5 хэргийн 2(40.0%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг байна. Тайлант хугацаанд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэсэн гэмт хэрэг 17(0.7%) гарсны хамгийн их нь 22 хороонд бүртгэгдсэн байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 794 бүртгэгдсэнээс 7-р хороонд 37(4.5%), 19-р хороонд 34(4.3%) тус тус бүртгэгдсэн байна. Хулгайлах гэмт хэрэг тус дүүргийн 6-р хороо 30(4.0%), 19-р хороо 37(5.4%), 26-р хороо 31(5.3%)-нд хамгийн их бүртгэгджээ. Залилан мэхлэх гэмт хэргийн 30(10.1%) нь 29 хороонд, 28(8.8%) 6-р хороонд бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд гарсан нийт өмчлөх эрхийн эсрэг хэргийн 729(53.3%) нь хулгайлах гэмт хэрэг, 77(12.9%) нь дээрэмдэх, 322(24.5%) нь залилан мэхлэх, 27(1.8%) нь хөрөнгө завших, 40(3.4%) нь алдаатай гүйлгээ, гээгдсэн эд хөрөнгө завших, 23(1.8%) нь эд хөрөнгө устгах, 27(2.1%) нь мал хулгайлах гэмт хэрэг байна.

Хүснэгт 12. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, төрлөөр, хороогоор

Хороо	Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Хүчиндэх	Хулгайлах	Малын хулгай	Дээрэмдэх	Залилан мэхлэх	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	Бусад	2020.XII	2019.XII
1	1		24	2	26	1		9		6	69	148
2	2	1	28	4	24		4	2	6	4	75	116
3			15	1	15		2	8	2	2	45	108
4	1		17	1	14			10	4	6	53	88
5		1	18	2	22		5	2	3		54	92
6	2		24	1	30		5	28	4	12	106	194
7	1	1	37	3	17		2	12	8	5	86	147
8			12		9			2		1	24	64
9	2		17	4	11			4	2	5	45	96
10	1		18	2	21		1	4	1	3	51	59
11	2	1	19		14			6	5	4	51	86
12	1		25		15		7	8		5	61	94
13			14	2	9		6	7	1	9	48	84
14			21		12		4	16		6	59	129
15			21	1	5		5	11	3	6	52	81
16			14		15		4	9		3	45	90
17	1		13		15		2	9	4	9	53	88
18	2		23		23		2	11	2	11	74	109
19	2		34	2	37		5	14	3	7	104	134
20		2	31		21	1	1	20	12	12	100	120
21			25	2	25	10		7	6	6	82	145
22		3	32	5	33	1	2	11	5	5	95	264
23	2	1	25	1	30		1	7			67	93
24	2		32	3	36		1	2	1	7	84	136
25		1	20	2	12		1	10	4	5	55	115
26	1	1	30	3	31	1	3	8	4		84	154
27		3	33	1	18		1	11	2	4	76	81
28		1	13	2	14		2	6	3		43	49
29	1		24		30		2	30	2	8	97	187
30		1	17		14			3	1	1	37	65
31			25	1	13		1	2		2	44	112
32	2		26		24	8	1	11	8	6	91	164
33			15	2	31	1	2	4	2	2	60	
34			5		16	4		1	3		30	
35			4	1	3						8	
36			6		17		1	2		2	30	
37			13		4		1	7		2	27	
38			9		2			1		1	14	
39	1		2					1	1		5	
40			2	1	7		1	1		2	14	
41			4	2	5		2	1	1	1	16	
42					6			3	1	2	12	
43			7		3			1			11	
Нийт дүн	27	17	794	51	729	27	77	322	104	174	2337	3692



МАЛ АЖ АХУЙ

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 80712 толгой мал тоологдсон байна. Энэ нь өнгөрсөн оноос 9944 (12.3%) толгой малаар өссөн байна. Нийт тоологдсон малын 24357(30.2%) нь үхэр, 10492(13.0%) нь адуу, 21739 (26.9%) нь хонь, 24124 (29.9%) нь ямаа тус тус эзэлж байна. Нийт малын 63147(78.2%) нь 21-р хороонд тоологдсон байна. Үүний 20830(33.0%) нь үхэр, 16834(26.6%) нь хонь, 17259(27.3%) нь ямаа, 8224(13.0%) нь адуу байна.

Хүснэгт 13. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	Бүгд	Хээлтүүлэгч	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл	
Бүгд	80 712	1 032	10 262	11 206	5 099	6 535
Адуу	10 492	423	1 172	1 139	669	657
Үхэр	24 357	214	2 907	3 663	1 322	2 514
Хонь	21 739	253	3 218	3 425	1 506	1 639
Ямаа	24 124	142	2 965	2 979	1 602	1 725

Хүснэгт 14. Малын тоо төрлөөр, бод, хонин толгойд шилжүүлснээр

Бод				
Бүгд	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
80 712	10 492	24 357	21 739	24 124
80 712	10 492	24 357	21 739	24 124
Бодод шилжүүлсэн				
Бүгд	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
41 487.7	10 492.0	24 357.0	3 623.2	3 015.5
41 487.7	10 492.0	24 357.0	3 623.2	3 015.5
Хонин толгойд шилжүүлсэн				
Бүгд	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
263 036.6	73 444.0	146 142.0	21 739.0	21 711.6
263 036.6	73 444.0	146 142.0	21 739.0	21 711.6

Хүснэгт 15. Тэжээвэр амьтдын тоо

Төрөл	Өрхийн тоо	Тоо	ААНБ-н тоо	Тоо
Гахай	29	1 029	3	3 875
Шувуу бүгд	56	870	1	36 000
Тахиа	54	801	1	36 000
Галуу	10	49	0	0
Цацагт хяруул	8	20	0	0
Туулай	7	19	0	0
Бусад	4	40	0	0

Дүүргийн хэмжээнд 2020 онд 29 өрхийн 1029 гахай, 3 ААНБ-ийн 3875 гахай, нийт 4904 гахай, 56 өрхийн 870 шувуу, 1 ААНБ-ийн 36000 шувуу, 7 өрхийн 19 туулай тус тус тоологдсон байна.

Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах
тоглоом

Валютын ханш








©2017

аппликейшнаас

СТАТИСТИКИЙН **мэдээллээ аваарай**

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас

 **1900-1212**

Цахим шуудан

 information@nso.mn

Холбоо барих
18082 Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг
27-р хороо Агарын гудамж
Дэлхийн зөн ОУБ-ын байр
Утас: 70171322, 70171660
И-мэйл: Songinokhairkhan@nso.mn
Вэб: www.ubstat.mn
www.shd.mn

